



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан  
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Зарим иргэд, байгууллага, албан тушаалтнаас болон байгууллагын албан хаагчид дотооддоо төрийн албан хаагчийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, хууль бусаар нөлөөлснөөс нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт зөрчигдөн улмаар авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, шүүхээр гэм буруутай нь тогтоогдон ял шийтгүүлэх зэрэг зөрчлийг таслан зогсоох, төрийн албан хаагчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газрын төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн удирдлага, албан хаагчдад ДААЛГАХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойших хугацаанд хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй, өргөсөн тангарагтаа үнэнч байж, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх;

2.Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлахгүй байх;

3.Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх, албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх зэрэг авлигын зөрчлийг хориглох;

4.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүргээ хэрэгжүүлэх;

5.Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглох;

17250003

6. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох, өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр бусдад хөндлөнгөөс нөлөөлөх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглох;

7. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авах, бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглох.

ДАРГА  НУУГАНБАЯР